

ТАНИЛЦУУЛГА

Сангийн яам болон Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт хандаж 2023 оны I улирлын байдлаар нийт 8,469 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн байна. Энэхүү өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг байгууллагаар харуулбал:

Сангийн яаманд	70
Гаалийн ерөнхий газарт	95
Татварын ерөнхий газарт	8,304

Дээрх өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн тухайд:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд салбарын хэмжээнд 2023 оны I улирлын байдлаар нийт 8,469 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 7,319 буюу 86.4 хувь нь хянан шийдвэрлэгдэж, 1150 буюу 13.6 хувь нь хариу өгөх хугацаа нь болоогүй, судлагдаж байна. Үүнээс:

Сангийн яаманд 2023 оны I улирлын байдлаар нийт 70 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 67 өргөдлийг буюу 95.7 хувийг хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн, үлдсэн 3 өргөдөл буюу 4.3 хувийн хариу өгөх хугацаа болоогүй шийдвэрлэхээр ажиллаж байна. Нийт өргөдлийн ихэнх хувийг улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулах тухай, гавъяат эдийн засагчийн тэтгэмж хүссэн, төрийн сангийн данс андуурч гүйлгээ хийсэн, компанийн санхүүгийн тайлангийн илгээх хугацааг сунгуулах тухай, архивын лавлагаа хүссэн, хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой болон дотоод өргөдөл эзэлж байна.

Нийт өргөдлийн 17 өргөдөл буюу 24.2 хувь нь дотоод өргөдөл байгаа бөгөөд ихэнх хувийг сургалт, хүүхэд асрах чөлөө хүссэн, ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, нэг удаагийн буцалтгүй тусламж хүссэн зэрэг өргөдөл эзэлж байна.

Гаалийн ерөнхий газарт нь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 95 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс бичгээр 65, “Info@customs.gov.mn” цахим хаягаар 13 хүсэлт ирүүлсэн байна. “Гаалийн лавлах 1800-1281” утсанд нийт 17 дуудлага, мэдээлэл /13 гомдол, 4 зөрчлийн мэдээлэл/ ирүүлсэн байна. “Гаалийн лавлах 1800-1281” утсанд хандан ирүүлсэн гомдол, мэдээллийг тухай бүр холбогдох албан тушаалтнуудад хуваарилж хугацаанд нь утсаар болон бичгээр хариуг нь өгч ажилласан байна.

Нийт 95 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс 81 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд 14 гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлт 86.4 хувьтай байна.

Татварын ерөнхий газарт хандаж 2023 оны 1 дүгээр улиралд Татварын ерөнхий газрын удирдлага, албан тушаалтанд хандаж нийт 8,304 өргөдөл, гомдол ирснээс 7,171 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн нь 86.4 хувийн үзүүлэлттэй байна.

Ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн:

- 106 нь бичгээр
- 273 нь утсаар /1800-1288, 1800-1212/
- 7923 нь цахимаар /и-баримт апплэкейшн, цахим шуудан, сошиал суваг/
- 2 нь биечлэн уулзсан байдлаар хандсан байна.

Иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, саналын нь 8,208 буюу 98.8 хувь нь гомдол, 87 буюу 1.05 хувь нь хүсэлт, 9 буюу 0.10 хувь нь санал, мэдээлэл гэсэн агуулгаар ирсэн байна.

Өндөр дүнтэй и-баримт бүртгэгдэхгүй, НӨАТ-ын буцаан олголт, урамшуулал олгогдоогүй гэх гомдол хүсэлтийн дагуу холбогдох нотлох баримтыг үндэслэн Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-т албан бичиг хүргүүлж, урамшууллыг нөхөж олгох, НӨАТ-ын хуулийн дагуу хариуг өгөх зэрэг арга хэмжээ авсан.

1800-1288 утсаар Татварын шинэчлэгдсэн багц хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль болон татварын тайлангийн маягтын өөрчлөлтийн асуудлаар хандсан иргэнд хариултыг тухай бүр өгч ажилласан байна.

НӨАТ-ын урамшууллыг олгохдоо Эрсдэлийн удирдлагын газраас “эрсдэлтэй” гэж үзэн, өндөр үнийн дүнтэй баримтыг цуцалсан бөгөөд иргэдээс нь холбогдох нотлох баримтыг гаргуулан буцаалтыг олгох, хуулийн дагуу хариуг өгөх зэрэг арга хэмжээ авсан. Мөн журамд заасан хугацаанд баримтаа шивээгүй, урамшуулал олгогдохгүй байна гэсэн гомдлыг Гааль, татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-т хүргүүлж, мэдээллийг шалгуулан, хуулийн дагуу хариу тайлбарыг хүргүүлсэн.

---oOo---

2023 оны I улирлын байдлаар иргэдээс гаргасан
 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт №1

Д)д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /хувиар/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Сангийн яам	70	67	-	-	3	95.7
2	Гаалийн ерөнхий газар	95	81	-	-	14	85.3
3	Татварын ерөнхий газар	8304	7171	-	-	1133	86.4
ДҮН		8469	7319			1150	86.4

2023 оны I улирлын байдлаар иргэдээс гаргасан
 өргөдөл, гомдол

Хүснэгт №2

Д)д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Бусад				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Сангийн яам	70	70	-	-	-	-
2	Гаалийн ерөнхий газар	95	35	13	17	-	-
3	Татварын ерөнхий газар	8304	106	7923	273	2	-
ДҮН		8469	241	7936	290	2	-

2023 оны I улирлын байдлаар иргэдээс гаргасан
өргөдөл, гомдлын агуулга (хувиар)

Нийт: 8469 өргөдлөөс

1. Гомдол	-	185 (2.18%)
2. Хүсэлт	-	8255 (97.47%)
3. Санал	-	15 (0.18%)
4. Мэдээлэл	-	14 (0.17%)
5. Талархал	-	0 (0.00%)

Хүснэгт №3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал	Тоо, нийт өргөдөл, гомдол эзлэх хувь
1	Сангийн яам	<p>Сангийн яаманд 2023 оны I улирлын байдлаар нийт 70 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 67 өргөдлийг буюу 95.7 хувийг хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн, үлдсэн 3 өргөдөл буюу 4.3 хувийн хариу өгөх хугацаа болоогүй шийдвэрлэхээр ажиллаж байна. Нийт өргөдлийн ихэнх хувийг улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулах тухай, гавъяат эдийн засагчийн тэтгэмж хүссэн, төрийн сангийн данс андуурч гүйлгээ хийсэн, компанийн санхүүгийн тайлангийн илгээх хугацааг сунгуулах тухай, архивын лавлагаа хүссэн, хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой болон дотоод өргөдөл эзэлж байна.</p> <p>Нийт гаргасан өргөдөл, гомдлыг ангилбал:</p> <ul style="list-style-type: none"> - Хүсэлт - 44 (62.8%) - Гомдол - 26 (37.2%) - Санал - 0 (0%) 	
2	Гаалийн ерөнхий газар	<p>Нийт 95 өргөдөл, гомдол, санал, хүсэлт /бичгээр, цахим шуудангаар, утсаар/ ирүүлсэн байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Хүсэлт - 54 (56.8%) - Гомдол - 21 (22.1%) - Санал - 15 (15.8%) - Мэдээлэл – 5 (5.3%) <p>Дээрх 95 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:</p> <p>Нэг. Өргөдөл:</p> <ol style="list-style-type: none"> 1.1. Ажилд орох тухай 30 буюу 48.3%, 1.2. Автомашины болон мэдүүлгийн лавлагаа хүсэх тухай 4 буюу 6.5%, 1.3. Гаалийн ажилтны ёс зүйн асуудал шийдвэрлүүлэх тухай 3 буюу 4.8%, 	

		<p>1.4. Улс хоорондын шудан илгээмж гаалийн газраас бараагаа авч чадахгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэх тухай 2 буюу 3.3%,</p> <p>1.5. Нөхөн бүрдүүлэлт хийлгэх тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.6. Түр горимын хугацаа сунгуулах тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.7. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын камер шүүлгэх тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.8. Татвараас чөлөөлүүлэх тухай 2 буюу 3.3%,</p> <p>1.9. Барааг шилжүүлэн авахад зөвшөөрөл авах тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.10. Хууль бусаар оруулж ирж байгаа бараанд зохих арга хэмжээг авч тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.11. Компаниудын экспортод гаргасан мэдээлэл хүсэх тухай 1 буюу 1.6%,</p> <p>1.12. Гаалийн байгууллагатай холбоотой санал хүсэлт 15 буюу 24.2%,</p> <p>/Ажилд эгүүлэн томилуулах тухай 6, Шалгалтад хамруулж, сул орон тоонд орох тухай 1, Ажлаас чөлөөлсөн тушаалыг эргэн харж өгөх тухай 1, Зөрчилтэй тушаалыг шийдвэрлэж өгөх тухай 1, Гаалийн ахмад настанд бүртгүүлэх тухай 1, Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулж өгөх тухай 2, Буцалтгүй тусламж хүссэн тухай 2 буюу, Гаалийн улсын байцаагчийн эрх хүсэх тухай 1/.</p> <p>Хоёр. Цахим шуудан:</p> <p>2.1. Хилээр авч гарах бэлэн мөнгөний хэмжээ лавласан 1,</p> <p>2.2. Гаалийн ерөнхий газарт албан хүсэлтийн загвар асуусан 1,</p> <p>2.3. Ажилдаа эргэн томилуулах тухай 1 ,</p> <p>2.4. Хилээр гарч, орсон тодорхойлолт хэрхэн авах тухай 1,</p> <p>2.5. Хаш аяга экспортод гаргахад бүрдүүлэлт хэрхэн хийх талаар 1,</p> <p>2.6. Хилээр авч орох барааны талаар лавласан 1,</p> <p>2.7. Автомашин татварын тухай 1 ,</p> <p>2.8. Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрийн тайлан хүссэн 1,</p> <p>2.9. Импортын мэдээлэл хүссэн 1,</p> <p>2.10. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний сургалт хэзээ болох тухай лавласан тухай 1,</p> <p>2.11. Гаалийн мэдүүлэг баримтын талаарх мэдээлэл хүссэн тухай 1,</p> <p>2.12. Ачаанд татвар ногдуулна гэсэнд дургүй байгаа тухай мэдээлэл ирүүлсэн тухай 1,</p> <p>2.13. Мах экспортлохтой холбоотой тодруулга хүсэх тухай 1 буюу 1.</p> <p>Гурав.Гомдол Бичгээр хандсан гомдол 3 байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БТКУС-тай холбоотой гомдолд арга хэмжээ авахуулах тухай, - А350 дугаар тушаалыг хүчингүй болгуулах тухай, - Хураасан хөрөнгийг хүчингүй болгуулах тухай. <p>Дөрөв. -“Гаалийн лавлах 1800-1281” утсанд Иргэдээс ирүүлсэн гомдол 13 буюу 76.5%, Тав. Зөрчлийн мэдээлэл</p>
--	--	--

		- Иргэдээс ирүүлсэн гаалийн зөрчилтэй холбогдолтой мэдээлэл 4 буюу 23.5% байна.						
3	Татварын ерөнхий газар	<p>Нийт өргөдлөөс:</p> <table style="margin-left: 40px;"> <tr> <td>Гомдол</td> <td>8208 / 98.8%</td> </tr> <tr> <td>Хүсэлт</td> <td>87 / 1.05%</td> </tr> <tr> <td>Мэдээлэл, санал</td> <td>9 / 0.10 %</td> </tr> </table> <ol style="list-style-type: none"> 1. Борлуулагч баталгаажуулаагүй – 3905/ 47% 2. Төлбөрийн и-баримтын асуудлаар - 3731 /44,9% 3. НӨАТ-ын буцаан олголтыг 10% болгох асуудлаар - 227 / 2,7% 4. Бусад асуудлаар – 384 / 4,6% 5. НӨАТ-ын урамшуулал олгогдоогүй, тайлан засварлах асуудлаар -57 /0,69 %-ийг тус тус эзэлж байна. <ul style="list-style-type: none"> • Борлуулагч баталгаажуулаагүй гомдлыг харьяа татварын албадад ирүүлсэн хаягийн дагуу хуваарилан өгч шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажилласан байна. • Гааль, татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-т хандан мэдээллийг засварлуулах, НӨАТ-ын урамшууллыг шилжүүлэх арга хэмжээ авсан байна. • Хуулийн тайлбар, татварын лавлагаа, тодорхойлолт, татварын тайлангийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөөг тухай бүр өгсөн байна. • Татварын албадад гомдлын шийдвэрлэлттэй холбоотой чиглэлийг хүргүүлж, арга зүйгээр хангаж, хяналт тавин ажилласан байна. • Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн материалыг хүлээн авах хугацаанд иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх Татварын улсын байцаагч нарыг харьяа нэгж, албадад нэмэлтээр томилон ажиллуулсан байна. 	Гомдол	8208 / 98.8%	Хүсэлт	87 / 1.05%	Мэдээлэл, санал	9 / 0.10 %
Гомдол	8208 / 98.8%							
Хүсэлт	87 / 1.05%							
Мэдээлэл, санал	9 / 0.10 %							

САНГИЙН ЯАМ